

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/33/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа
Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com
Аудитор: Н.Энхтуяа
Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	БАЯННУУР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.ТОЙЛЫБАЙ ТАНАА
<u>2023.02.17 № 73</u>	
танай _____-ны № _____ 2-Т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,071,087.22</u>	<u>50,279,053.22</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	17,354,462.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	17,354,462.00
3122	Гадаад валют	-	17,354,462.00
31221	Төрийн сангийн харилцах	-	17,354,462.00
33	АВЛАГА	174,773.00	174,773.00
335	Бусад авлага	174,773.00	174,773.00
3351	Байгууллагаас авах авлага	174,773.00	174,773.00
35	БАРАА МАТЕРИАЛ	26,896,314.22	32,749,818.22
354	Хангамжийн материал	26,896,314.22	32,749,818.22
35410	Бичиг хэргийн материал	835,100.00	835,100.00
35420	Аж ахуйн материал	21,514,912.00	24,045,412.00
35440	Түлш, шатах тослох материал	1,179,623.29	2,655,373.29
35460	Хүнсний материал	2,104,678.93	4,075,932.93
35470	Бусад хангамжийн материал	1,138,000.00	1,138,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>109,266,028.83</u>	<u>112,449,807.69</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	109,266,028.83	112,449,807.69
392	Биет хөрөнгө	79,266,028.83	82,449,807.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	71,129,400.00	71,129,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,172,280.60)	(23,337,318.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,929,876.00	47,090,476.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,589,167.59)	(30,049,926.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,323,107.10	40,593,107.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,141,669.07)	(32,862,625.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,788,900.00	14,788,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,694,055.26)	(8,594,123.47)
39217	Ном	3,691,918.25	3,691,918.25
393	Биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000.00)	(275,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>136,337,116.05</u>	<u>162,728,860.91</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>315,822.00</u>	<u>306,912.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	315,822.00	306,912.00
413	Өглөг	315,822.00	306,912.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	306,912.00	306,912.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>136,021,294.05</u>	<u>162,421,948.91</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	136,021,294.05	162,421,948.91

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	89,898,883.00	89,898,883.00
51102	- хувийн	89,898,883.00	89,898,883.00
512	Хуримтлагдсан үр дүн	(14,233,978.30)	12,166,676.56
51210	Өмнөх үеийн үр дүн	(14,233,978.30)	(14,233,978.30)
51220	Тайлант үеийн үр дүн	-	26,400,654.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,356,389.35	60,356,389.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>136,337,116.05</u>	<u>162,728,860.91</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	293,197,633.00	375,958,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	5,000,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	5,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	293,197,633.00	370,958,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	288,775,900.00	370,958,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	275,694,900.00	328,025,200.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	13,081,000.00	42,933,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	307,974,483.16	349,557,945.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	307,974,483.16	349,557,945.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	294,745,655.16	327,446,361.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,631,036.00	241,050,992.00
210101	Үндсэн цалин	196,648,436.00	241,050,992.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,772,445.57	29,652,500.00
210201	Тэтгэврийн даатгал	28,772,445.57	20,163,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,372,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,898,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	474,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,744,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,108,750.00	13,323,250.00
210301	Гэрэл, цахилгаан	1,264,000.00	1,764,000.00
210302	Түлш, халаалт	8,844,750.00	11,559,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,323,202.00	1,222,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,575,000.00	1,222,800.00
2105	Нормативт зардал	16,400,485.00	20,678,538.00
210502	Хоол, хүнс	15,759,285.00	20,678,538.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	376,000.00	124,000.00
210604	Урсгал засвар	376,000.00	124,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	470,600.00	132,000.00

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,510,736.59	21,262,281.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,302,060.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	331,000.00	1,713,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,179,736.59	12,246,821.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,228,828.00	22,111,584.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,655,045.00	16,666,584.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,655,045.00	11,878,638.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,787,946.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,139,000.00	5,445,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,139,000.00	5,445,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(14,776,850.16)	26,400,654.86
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(14,776,850.16)	26,400,654.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	293,197,633.00	370,958,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	293,197,633.00	370,958,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	275,694,900.00	328,025,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		328,025,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,081,000.00	42,933,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,081,000.00	42,933,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	288,948,933.00	343,243,538.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,948,933.00	343,243,538.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	277,424,250.00	318,618,612.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,761,500.00	241,050,992.00
210101	Үндсэн цалин	192,684,779.00	175,518,058.00
210102	Нэмэгдэл		59,595,054.00
210104	Урамшуулал	10,463,321.00	5,937,880.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,353,900.00	29,652,500.00
210201	Тэтгэврийн даатгал	20,656,500.00	20,163,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,174,300.00	2,372,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,739,500.00	1,898,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	434,800.00	474,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,348,800.00	4,744,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,442,000.00	14,799,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,264,000.00	1,764,000.00
210302	Түлш, халаалт	7,178,000.00	13,035,000.00
2105	Нормативт зардал	16,589,650.00	20,438,120.00

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	15,669,350.00	20,438,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	535,600.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,795,000.00	12,046,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,000.00	9,651,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,635,000.00	2,394,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,524,683.00	24,624,926.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,950,900.00	19,179,926.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,950,900.00	14,391,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,787,946.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,139,000.00	5,445,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,139,000.00	5,445,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,248,700.00</u>	<u>27,715,062.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,248,700.00	10,360,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,248,700.00	10,360,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,248,700.00	10,360,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,248,700.00	10,360,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(4,248,700.00)</u>	<u>(10,360,600.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	17,354,462.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		17,354,462.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	89,898,883.00	60,356,389.35	-14,233,978.30	136,021,294.05
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	89,898,883.00	60,356,389.35	-14,233,978.30	136,021,294.05
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,898,883.00	60,356,389.35	-14,233,978.30	136,021,294.05
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	89,898,883.00	60,356,389.35	-14,233,978.30	136,021,294.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	89,898,883.00	60,356,389.35	-14,233,978.30	136,021,294.05
D08	Тайлант үеийн үр дүн			26,400,654.86	26,400,654.86
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,898,883.00	60,356,389.35	12,166,676.56	162,421,948.91

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	370,958,600.00	348,159,138.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	370,958,600.00	348,159,138.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	350,299,500.00	328,979,212.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,249,300.00	241,050,992.00
210101	Үндсэн цалин	193,073,600.00	175,518,058.00
210102	Нэмэгдэл	45,142,400.00	59,595,054.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,033,300.00	5,937,880.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,652,500.00	29,652,500.00
210201	Тэтгэврийн даатгал	20,163,400.00	20,163,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,372,100.00	2,372,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,898,100.00	1,898,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	474,700.00	474,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,744,200.00	4,744,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,244,000.00	14,799,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,764,000.00	1,764,000.00
210302	Түлш, халаалт	18,480,000.00	13,035,000.00
2105	Нормативт зардал	33,082,000.00	20,438,120.00
210502	Хоол, хүнс	33,082,000.00	20,438,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,511,800.00	1,511,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,511,800.00	1,511,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,059,900.00	21,026,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,665,200.00	18,632,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,394,700.00	2,394,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,659,100.00	19,179,926.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,659,100.00	19,179,926.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,802,700.00	14,391,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,856,400.00	4,787,946.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	370,958,600.00	370,958,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	328,025,200.00	328,025,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	328,025,200.00	328,025,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,933,400.00	42,933,400.00
132007	Орон нутгийн төсвөөс	42,933,400.00	42,933,400.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	84.00	84.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	84.00	84.00
630001	Төрийн өмчит ЕБС	84.00	84.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.00	19.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсөв аваагүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус сургууль нь 2022 онд “Суралцагчийн сурлагын хоцрогдлыг нөхөж, бие даан сурах үйлийг дэмжихэд бүх талын оролцоог ханган, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж үр дүнтэй хэрэгжүүлэх
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг ахиулах
- Даалгаварт суурилсан арга зүйг боловсруулж, сургалтын чанарт ахиц гаргах.
- Багш, ажилчид, сурагчдыг стрессээс сэргийлэх, айдас түгшүүр, сэтгэл зовнилгүй ажиллах, суралцахад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бүрдүүлэх
- Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжүүлэх, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжин оролцоог хангаж, сургууль завсардахаас сэргийлэн, эцэг эх олон нийттэй хамтран ажиллах.
- Монгол хэл бичгийн чадварыг сайжруулах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх.
- "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3"-ын хүрээнд сургуулийн мэргэжлийн бүлгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх.
- Сурагчдыг тэгш хамааруулан сургах үйлийг дэмжих дэмжлэгийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн захирлын 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 06 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26.4 сая төгрөгөөр буюу 16.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	17.354.5	17.354.5
Авлага	174.8	174.8	-
Бараа материал	26.896.3	32.749.8	5.853.5
Үндсэн хөрөнгө	109.266.0	112.449.8	3.183.8
Нийт хөрөнгө	136.337.1	162.728.9	26.391.8
Өр төлбөр	315.8	306.9	-8.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	136.021.3	162.421.9	26.400.6
<u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u>	136.337.1	162.728.9	26.391.8

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 17.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь батлагдсан төсвөөс цалингийн зардал, нормативт зардал, урсгал шилжүүлэг, бараа үйлчилгээний бусад зардлуудын хэмнэлт байна. Цалингийн хэмнэлт 3,2 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 18.5% хувийг, нормативт зардал 12.6 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 72.8 хувийг, урсгал шилжүүлэг 1,5 сая буюу нийт хэмнэлтийн 8.6 хувийг, бараа үйлчилгээний бусад зардлын хэмнэлт 0.03 сая төгрөг буюу нийт хэмнэлтийн 0.1 хувийг тус тус эзэлж байна.

Авлагын дансны өөрчлөлтгүй байна.

Үндсэн хөрөнгийн данс 3.2 сая төгрөгөөр өссөн нь 15.4 сая төгрөгийн хөрөнгийг нэмж орлого авч, үндсэн хөрөнгөнд тайлант онд 12.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 389.0 сая, орон нутгийн төсвөөс 42.9 сая, нийт зарлагыг 431.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

БӨА-2023/33/НА-СТА-ТШЗ

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас зардлыг 61.0 сая төгрөгөөр бууруулж 370.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 328.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 42.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 310.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 37.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 348.2 сая төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь үндсэн цалингийн зардлын төсвийг 3.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 5.4 сая төгрөгөөр, нормативт зардлыг 9,7 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.03 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 1,5 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	421.0	421.0	-	100.00%
2	Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	210.5	210.5	-	100.00%
3	Эрүүл мэндийн арга хэмжээ	684.2	684.2	-	100.00%
4	Нийтлэг үйлчилгээ	42,933.4	37,488.4	5,445.0	87.32%
5	Боловсролын арга хэмжээ	186,069.1	185,460.1	608.8	99.67%
6	Үдийн цай хөтөлбөр	15,802.7	14,391.90	1,410.7	91.07%
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	7,495.0	7,462.0	33,000.00	99.56%
8	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,379.4	1,379.4	-	100.00%
9	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	66,166.2	63,508.2	2,658.0	95.98%
10	Дотуур байрны үйлчилгээ	49,797.1	37,153.2	12,643.9	74.61%
	Дүн	370,958.6	348,159.0	22,799.4	93.85%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

БӨА-2023/33/НА-СТА-ТШЗ

Баяннуур сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор Н.Энхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 308.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100.0% байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Баяннуур сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуульд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 15.0 сая төгрөгийн 1 акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	545.0	1	545.0	100%
Албан шаардлага	1	11.126.7	1	11.126.7	100%
Зөвлөмж	2	3.371.1	1	3.371.1	100%
Нийт дүн	1	15.042.8	1	15.042.8	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 5.4 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт орон нутгийн төсвөөс төвлөрүүлэг шилжүүлэг 5.4 сая төгрөгийг хасаж цэвэрлээгүй тайлагнасныг залруулсан.

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрээс төвлөрүүлэг шилжүүлгийг цэвэрлээгүй	1	5.445.0			1	5.445.0	1	5.545.0				
Дүн	1	5.445.0			1	5.445.0	1	5.545.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/ Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/ Үүнээс	
							Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								